

Түрэгийн хожуу улсын хааны угсааны титэм, түүний уламжлал, соёлын тухайд

Цан хай (Өргөндалай)^{1, 2 *}

Товч агуулга: Түрэгийн хаант улсын хааны титэм нь Ашина овгийн нийгмийн байр суурь, хэргэм зэргийг төлөөлдөг. Одоогоор Түрэгийн хожуу хаант улсын хаадын тахилын онгоны цогцолбор газраас олдсон хааны титмийн тухай олдвор гэвэл Билгэ хааны алтан титэм, Күлтегиний чулуун хөрөг, Кутлуг хааны чулуун хөрөг зэрэг бий. Эдгээр археологийн малтлагаас илрүүлсэн үнэт олдвор болох Түрэгийн үеийн хааны титэм нь тухайн үеийн шашин шүтлэг, зан үйл, хувцас заслын соёлыг шинжлэн судлахад тун их үнэ цэнтэйгээр барахгүй, Түрэг хийгээд Тан улсын соёлын солилцоог судлахад маш чухал эрдэм шинжилгээний үнэ цэнтэй юм. Тус өгүүлэлд түүхийн сурвалжийн мэдээ болон археологи, угсаатан зүйн эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан, Түрэгийн хоёрдугаар хаант улсын хаан угсааныхны титмийн хэлбэр дүрс, хийц маяг, уламжлал хувирлыг тодруулах, соёлын агуулгыг нарийвчлан авч үзэхийг зорив. Жич хятад үгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн гаргасан хятад хэлний үеийн галиг баримтлан буулгав.

Түлхүүр үг: Түрэгийн хожуу хаант улс, титэм, шувуу шүтлэг, соёлын солилцоо

Удиртгал

Эртний хаад ноёдын эрх сүр, хэргэм зэргийн бэлэг тэмдэг болсон титэм, түүний загвар хийц, дүр дүрслэлээс нэг улс гүрний хөгжил бадрал, соёл иргэншил, зан үйл зэрэг олон талыг судлан шинжилж болдог. Үүний нэгэн адил, Түрэг хаант улсын хаадын титэм нь эрхэмсэг язгууртны хамгийн дээд байр суурийн бэлгэдэл болж байдаг. Дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын Түрэгийн хаадын титмийн тухай судалгааны бүтээл өдий төдий бий.

Үүнд Монгол Улсын нэрт эрдэмтэн Н.Сэр-Оджав (1959: 8), Д.Баяр (2021: 76), Япон улсын эрдэмтэн М.Ишивата (石渡美江 Miye Ishivata) (石渡美江 2019: 120-140) нарын судалгааны бүтээлд хаадын титмийн тухай дурдаж өнгөрсөн боловч хараахан гүнзгий судалгаа хийгээгүй байна.

Билгэ хааны үнэт эрдэнэсийн санд тулгуурласан дотоод, гадаадын олон эрдэмтдийн судалгаа цөөнгүй байна. Тэдгээрээс дурдвал, БНХАУ-ын улсын судлаач Чэнь Лин (陈凌 Chen Ling) “Түрэгийн хаадын титмийн тухай судлал- Түрэгийн гал мөргөлийн шүтлэгийн холбогдол бүхий асуудлын тухай өгүүлэх нь” (陈凌, 突厥王冠考——兼论突厥袄教崇拜的有关问题 2008) гэх өгүүлэлд археологийн малтлагаас илрүүлсэн Түрэгийн хаадын титмийн хийц хэлбэрийн онцлогийг үндэслэн он цаг, төрлөөр нь ангилан хувааж,

түүхэн хувиралтын явцыг тодруулахыг хичээжээ.

Вэй Жы Хао (韦之昊 Wei zhi hao)-ийн “Монголоос олдсон эртний титэм дээрх домогт шувуу” (蒙古草原古代头冠上的神鸟——北方民族鸟形头饰的初步研究) хэмээх өгүүллийн гуравдугаар бүлгийн агуулгад, “Эртний Түрэгийн шувуун чимэгтэй титмийн залгамж холбоо хамаарал, хувьсал хувирал, соёлын агуулагдахууныг судалж өөрийн үзэлтийг дурджээ (韦之昊 2023: 37-81).

Линь Мэй Цүн (林梅村 Lin mei cun)-ийн “Билгэ хааны эрдэнэс хийгээд дундад зууны үеийн тал нутгийн урлаг” (林梅村, 毗伽可汗宝藏与中世纪草原艺术 2005) Хөү Вэй (霍巍 Huo wēi)-ийн Түрэгийн хааны титэм хийгээд Төвд (吐蕃 tubo) хааны титэм” (霍巍 2009) зэрэг өгүүлэлд Түрэгийн хааны титмийн тухай дурдсан боловч гүнзгий судалгаа хийсэнгүй.

Одоогоор эрдэмтэд Түрэгийн хоёрдугаар хаант улсын хааны титэм, онцгойлон титэм дээрх шувууны дүр дүрс бүхий чимэглэл, түүний соёлын агуулагдахууныг тайлбарлах, Түрэг хийгээд Тан улсын соёлын солилцооны тухай судалгааг гүнзгийрүүлэхийг хичээж буй.

Археологийн малтлагаар илрүүлсэн Түрэгийн хожуу хаант улсын хааны угсааныхны титэм

Монгол Улс болон Чехословак улсын археологийн хамтарсан хээрийн шинжилгээний анги аль эрт 1958-1959 онд Монгол Улсын Архангай аймгийн Хашаат сумын нутаг Орхон голын зүүн эрэг дэх Цайдам нуурын баруун өмнө, Хөшөө Цайдамд орших Түрэгийн хоёрдугаар хаант улсын жанжины

¹ БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль, Угсаатны зүй, нийгмийн ухааны сургууль

² ӨМӨЗО-ны Археологийн хүрээлэн

* Холбоо барих зохиогч: changhai09@126.com

тахилын онгоноос 41 см өндөртэй чулуун хөргийн толгойн хэсгийг илрүүлсэн боловч их биеийн хэсэг нь олноогүй байна.

Тус чулуун хөрөгт нарийн хэмжилт хийсний дүнд, царайны өндөр нь 28 см, өргөн нь 16 см, малгайн хэвсэгийн хоёр хажуугийн өндөр тус бүр 16 см, өргөн 13 см болохыг тогтоожээ. Чулуун хөргийн дүр байдлыг ажиглавал, Күлтегин дөрвөн талтай хэвсэг бүхий өндөр цохтой, бусад гурван тал нь мөлгөр, богиновтор малгай өмсөж титмийн суурьт өргөн эмжээр хатсан байна.

Уг малгай нь үл мэдэгдэм бөмбөгөр оройтой бөгөөд ар шил рүүгээ гурван хэсэг бүч унжуулсан титэмт малгай болно. Тус титмийн тодорхой нэг онцлог гэвэл магнайн хэсэгт нь далавчаа дэлгэн нисэхийг завдаж буй шувуу сийлжээ. Чулуун хөргийн нүүр царайны дүр төрхийг ажиглавал, өргөн төвлүүн царай, зузаавтар уруул, ихэмсэг дөлгөөн харц, өндөр босоо хамартай, чихэндээ жижигхэн гархин ээмэг зүүсэн дүр байдалтайгаар урлан сийлсэн (Сэр-Оджав 1959: 8) нь монголжуу төрхийг илтгэх бөгөөд Түрэгийн цэргийн нэрт жанжин Күлтегиний бодит дүр болох нь дамжиггүй (Зураг 1.1).

Монгол-Туркийн хамтарсан хээрийн шинжилгээний анги 2001 оны 8-9 дүгээр сард “Орхоны хөндий дэх Түрэгийн үеийн хөшөө дурсгалыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах”

төслийн хүрээнд Монгол Улсын Архангай аймгийн Хашаат сумын нутаг, Орхон голын зүүн эрэг, Цайдмын хөндийд орших Түрэгийн хоёрдугаар хаант улсын Билгэ хааны тахилын онгонд археологийн малтлага судалгаа хийжээ. Энэхүү судалгааны явцад 2000 гаруй үнэт олдворыг малтан илрүүлсэн байна. Энэ бүлэг үнэт эрдэнэсийг “Билгэ хааны эрдэнэс” хэмээн нэрлэх бөгөөд тэдгээрээс Билгэ хааны алтан титэм нь эрдэмтдийн анхаарлыг хамгаас илүү татжээ.

Билгэ хааны тайлгын цогцолборыг малтан судалсан археологич Д.Баяр, Ч.Амартүвшин, А.Энхтөр, Ж.Гэрэлбадрах нар малтлагаас илэрсэн алтан титмийг “Цэцгэн хээ бүхий тууш хөндлөн сууринаас (хантайрга) дээш салбарласан таван дэлбээтэй. Голын том дэлбээ нь (магнайвч) далавчаа дэлгэсэн шувуу эгц урдаас нь дүрсэлсэн байна. Өндөр 9 см. Шувууны толгойг тусад хийж хоёр хадаасаар хадаж тогтоожээ. Шувууны толгойн дээр залаа бололтой овгор байна. Шувуу амандаа 4 см урт алтан утсанд тунгалаг ягаан өнгийн үнэт чулууг сүвлэн суулгажээ. Шувууны хошуу махир бөгөөд шовх байгаа нь махчин шувуу бололтой. Хамар болон нүдийг нь тод сийлж гаргасан байна. Шувууны хүзүү үл ялиг урагш товойлгон хайрсан хэлбэрээр тодруулан үйлджээ. Шувууны зүүн далавчинд 0,91 см, баруун далавчинд 1,04 см хэмжээтэй дугуй нүхийг тус тус гаргажээ. Энд ямар нэгэн зүйлийг тогтоох зорилгоор тус тус гурван



Зураг 1. Түрэгийн хоёрдугаар хаант улсын хаан угсааныхны титэм
1. Күлтегиний чулуун хөргийн толгойн хэсэг, 2. Билгэ хааны алтан титэм
3. Күлтегин хааны чулуун хөргийн толгойн хэсэг

сэртэнг дотроос нь гадагш цохин гаргасан байна. Хоёр далавчны үзүүрт тус бүр зургаан урт өдийг тод дүрсэлсэн байна. Шувууны толгойн чанх ард сүүлийг нь 13 ширхэг дугариг гарган товойлгон дүрсэлжээ.

Сүүлийн голд 1,07 см голчтой нүх гаргасан нь ямар нэгэн зүйлийг тогтоох зориулалт бүхий дөрвөн сэртэнг дотроос цохин гаргасан байна. Хоёр далавчны өдний угт тус бүр дээрээс доош хагас дугуй хэлбэрээр цувруулан найман хонхрыг цохиж гаргажээ. Таван дэлбээний доод төгсгөлд дөрвөлжин тууш товгор хүрээг гаргаад дотор нь 5 ширхэг ямар нэгэн зүйлийн суулгаж тогтоох зориулалт бүхий сэртэнтэй нүхийг гаргасан байна. Дунд талын гурван нүх нь дөрвөн сэртэнтэй, хоёр талынх нь гурван сэртэнтэй байна. Нүх 0,81 см хэмжээтэй дунд талд нь буй нүхнээс хоёр тийш салбарлуулан эвэр угалзыг гаргасан байна. Хантайрга хэмээх дунд талын тууш дөрвөлжин хээ бүхий суурийг нэрлэж байна. Голын дэлбээг магнайвч, хоёр захын жижиг дөрвөн дэлбээг хал хэмээн нэрлэж байна. Хоёр захын жижиг дэлбээг тус тус хоёр нүхтэй (голч 0,91см), гурван сэртэнтэй бөгөөд хос эвэр угалзыг орооцолдуулан хөөж гаргасан байна. Захын хоёр дэлбээ нь гурван сэртэн бүхий нэг нэг нүхтэй бөгөөд дан эвэр угалзыг хөөн цохиж гаргасан байна” (Баяр 2021: 76) хэмээн маш нарийн тодорхойлж бичсэн байдаг (Баяр 2004: 214-223) (Зураг 1.2).

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн болон Олон Улсын Түрэгийн Академитай хамтарч 2022 онд Архангай аймгийн Хашаат сумын нутаг, Номгоны хөндийд орших эртний Түрэгийн тахилын онгон цогцолборт археологийн малтлага судалгаа хийсэн байна. Үүний үрд дүнд “Номгон-2” тахилын онгон цогцолборт хийсэн археологийн малтлагын явцад Түрэгийн хожуу хаант улсыг үүсгэн байгуулагч Кутлуг хааны тахилгын онгоноос титмийн засалтай чулуун хүнийг илрүүлжээ. Цайвар өнгийн том ширхэгтэй боржин чулуугаар хүний толгой хэсгийг сийлсэн байх бөгөөд Күлтегиний чулуун хөрөг дэх титэмт малгайны загвартай төстэй титэм зүүсэн ажээ. Тус чулуун хүнийг Кутлуг хаанд зориулсан тахилгын онгоноос малтан илрүүлсэн учир Кутлуг хааны чулуун хөрөг гэж үзэцгээжээ.

Чулуун хүний дүрс байдлыг ажиглавал, дунд эргэм насны эрэгтэй хүний дүр төрх тод харагдах ба малгай засал нь таван дэлбээ бүхий титэм хэлбэртэй. Толгойн оройноос эхэлсэн зовхи нь гүдгэр болж хамар хүртэл үргэлжилсэн ба хамрын үзүүр дугуй хэлбэртэй. Нүд нь ялимгүй аньсагатай, нүүр нь зууван, эрүү нь дугуй ажээ. Хүн чулуунд малгайны титэм нь Түрэгийн хааны титэм болох нь тодорхой бөгөөд таван дэлбээтэй буй нь Күлтегиний чулуун хөргийн титэм, Билгэ хааны алтан титмийн хэлбэртэй адилавар юм (Энхтөр 2022: 69-87) (Зураг 1.3).

Түрэгийн хожуу хаант улсын хаан угсааныхны титэм, малгай ба тэдгээрийн улирал хувирал

Түрэгийн хожуу хаант улсыг үүсгэн байгуулагч Кутлуг хааны чулуун хөрөг дэх титэм, Билгэ хааны алтан титэм, Күлтегиний чулуун хөрөг дэх титмийн хэв маяг ба хэлбэр дүрс нь бүгд таван дэлбээт цэцгийн хэлбэртэй юм.

Билгэ хааны алтан титмийн магнай хэсгийн том цэцгийн дэлбээ дээр жигүүрээ дэлгэсэн шувууг сийлснээс гадна, бусад дөрвөн дэлбээ дээр нь хээ угалз сийлж сувд эрдэнэ шигтгэжээ. Кутлуг хаан ба Күлтегиний чулуун хөрөгт сийлсэн таван дэлбээт титмийн дүрс хэлбэр нь Билгэ хааны алтан титмийн дүрс онцлогтой адилавар боловч, бодит бие ба сийлмэл чулууны онцлогоос шалтгаалж хэлбэр дүрсийн талаар багахан зөрөөтэй шиг санагддаг.

Чулууны материал, чулуучийн мэргэжил, танин мэдэхүйн түвшин зэргээс шалтгаалан, хүн чулууны титмийн заслыг сийлэх үед янз хэлбэрийг нь нарийн сайн дүрсэлж чадаагүй байж болох юм. Бидний үзэж буйгаар бол, Түрэгийн хожуу хаант улсын үед дэлгэрсэн таван дэлбээт титэм бол түрэг угсаатны үүслийн газар болох Алтай болон Төв Азийн газар оронд дэлгэрсэн гурван дэлбээт титэм заслаас хувирч ирсэн байна. Гурван дэлбээт титмийн дүрс хэлбэрийг үндэслэн, зарим эрдэмтэд бас “山” хэлбэрт титэм буюу “Гурван дэлбээт титэм” хэмээн нэрлэж байх ба титмийн бодит олдвор олодоогүй боловч чулуун сийлмэл, ясан сийлмэлийн дүрст олон тохиолдож байна.

Оросын археологич Н.Руденко 1924-1925 онд Алтайн зүүн хэсгээс Кудыргэ тахилын онгоны газарт хийсэн малтлага судалгааны явцад булш (M16) -наас 40 см өндөр хүн чулууг илрүүлжээ. Тус хүн чулууг нарийн урт хөмсөг, жартгар нүд, хамрын доор нь ооч сахалтай эрэгтэй хүнийг эвэр хэлбэрт засал бүхий малгай өмссөн байгаагаар дүрсэлжээ.

Чулуун хүний ар талын зураглалд гурван дэлбээт титэм зүүж, хээнцэр урт тэрлэг өмссөн эмэгтэй хүнийг завиалан сууж байгаагаар сийлсэн байна.

Түүний ард толгойдоо малгайн засалгүй, чихний унжлага, хээ угалз бүхий дээл өмссөн нэгэн хүүхдийг нэлээд бага хэмжээтэй зураглан сийлж, хажууд нь бас сум саадаг тавиастайгаар сийлжээ. Тэдний өмнө гурван морьтой хүн мориноосоо бууж, сөгдөн золгож байгаа үзэгдлийг зураглажээ. Гурван морьтой хүний төрх байдлыг сийлж зурагласныг ажиглавал, зүүн дээр талын нэгдэх хүн нүүрэндээ баг зүүсэн эрэгтэй хүний дүр байдалтай. Түүний доод талд нь морио хөтөлж сөгдөх хоёр дахь хүний дүр төрх нь эмэгтэй хүний бие галбиртай бөгөөд толгойдоо бас гурван дэлбээт титэм зүүжээ. Гурав дахь хүн нь дугуй малгай өмсөж, бүсэндээ сэлэм зүүж, сөгдөн мөргөж

байхаар зураглажээ. Гурван моринд хазаар ногт, эмээл засал бүрэн байхаар зурагласан мөртлөө нэг морь нь арай зайдуу идээшилж байгаагаар амьдлаг зураглан сийлжээ. (Кубарев 1984: 155) (Зураг 2.1).

Кудыргэгийн Түрэгийн тахилын онгоны хамаарах он цагийн судалгааны талаар Оросын эрдэмтэн Ю.С. Худяков Түрэгийн түрүү хаант улсын Түмэн хаанаас өмнө Алтайн эртний Түрэг улс бий болсон цаг үеэс эрт байжээ” (даруй VI зууны өмнө хагасаас өмнө) хэмээн үзэж буй. (吉谢列夫著, 王博译 2014)

Кудыргэгийн Түрэгийн тахилын онгоны газрын булшны (M16) оройн чулууны зураглал дахь хүний дүр байдлыг зохих харьцаагаар томруулан сийлснээс үзвэл, эгэл харц иргэдээс хэтийдсэн байр суурьтай эмэгтэй хүний дүр төрхийг төлөөлж, Түрэгийн хөшөөний бичээст тэмдэглэгдсэн умай дагина, харин мориноосоо буусан хүмүүсийн дотор гурван дэлбээт титэм зүүсэн эмэгтэй нь Түрэгийн эрхэм дээд язгууртан бололтой (Руденко 1927: 51). Зураг дахь насанд хүрсэн эмэгтэйчүүд цөм гурван дэлбээт титэм зүүсэн нь Түрэгийн эрхэм дээд байр суурьтай эмэгтэйчүүдийн дунд гурван дэлбээт титэм ихээхэн таашаагдаж өргөнөөр тархан дэлгэрснийг харуулж байна.

Төв Азийн Долоон усны голын сав газарт Түрэгийн үеийн онгон ба тахилгын ёслолд хэрэглэсэн ясан сийлмэл дээрх хүн болон оршуулгын ёслолд босгосон чулуун хүнийг гурван дэлбээт титэм зүүж байгаар урлан сийлжээ.

Киргиз улсын Тэнгэр уул дахь Суттуу-Булак-54 дугаар булшнаас хэлбэр хийц адилавар хоёр хэсэг ясан сийлмэл хавтсыг илрүүлжээ. Тус хоёр ясан сийлмэлийн дээд хэсгийг загасны сэлүүрийн хэлбэрээр сийлж, дээр нь загасны хайрсыг угалзаар урлаж, эгц шулуун зураасаар хөвөөлөн, доод хэсгийг жишүү зураасаар тусгаарлажээ.

Нэг ясан сийлмэлийн доод хэсэгт хурим найрын ёслолын үзэгдлийг гол сэдэв болгон сийлж зураглажээ. Энэхүү хурим найрын ёслолд буруу энгэртэй урт тэрлэг өмссөн нэгэн эрэгтэй гурван дэлбээт титэм зүүж, эсгий гэрийн гол суудалд төвлүүн байдалтай завилан суужээ. Түүний баруун гар талд эрэгтэй дагагсад нь сөгдөж, гартаа таваг барьж, эзэндээ дэвшүүлэн өргөж байгаа байдалтай. Нөгөө нэг ясан сийлмэл нь дайн байлдааны ахуй үзэгдлийг дүрсэлжээ. Тус сийлмэлд хоёр этгээдээрээ эсэргүүцэлдэн байлдаж байгаа зургаан дайчдын дүр төрхийг тодорхой дүрсэлжээ. Зүүн гар талын гурван дайчны гадна дүр төрх ба өмсгөл заслаас үзвэл, Түрэгийн үеийн хүний дүр төрх байх ба тэр үеийн өмсгөл засалтай адилхан, гурван дайчид бүгд урт гээг, өндөр босоо хамартай. Тэдний дундах хоёр дайчин нь загасны хайрстай хуяг дуулга өмсөж, нум сум харван эсэргүүцэлдэн байлдаж, гурав дахь дайчин нь гартаа урт сэлэм атган дайсантай

тулалдаж байгаар дүрсэлжээ. Баруун гар талын гурван богино үс гээгтэй, өндөр босоо хамартай. Түүний доторх хоёр дайчин нь хуяг дуулга өмсөж нум сум тэлэн эсэргүүцэлдэн байлдаж, гурав дахь дайчин нь газар мөлхөж байгаа байдалтайгаар дүрсэлжээ. Тус булшинд малтлага судалгаа хийсэн судлаачийн үзэж буйгаар байлдааны ахуй байдлыг зурагласан дүрслэлийн дотор, баруун гар талын урт гээгтэй дайчин нь түрэг хүн, зүүн гар талын богино гээгтэй дайчин нь согд хүн, VII-VIII зууны үеийн үзэгдлийг дүрсэлсэн гэж үзсэн байна. (Худяков 1997: 145, 147) Хэрэв энэ магадлал нь зөв гэвэл, энэхүү зураг сийлмэл нь дундад зууны үеийн түрэг хүний дүр төрх, хувцас засал, титэм малгайны хэв загвар, хэлбэр хийцийг үнэн бодитойгоор тусгасан байж болох юм (зураг 2.2). Одоогийн археологийн судалгааны үр дүнг үндэслэвэл, Түрэгийн үеийн хүн чулуун дотор гурван дэлбээт титэм зүүж байгаагаар сийлсэн нь төв Азийн Казахстан, Киргиз, БНХАУ-ын Шиньжаан Уйгурын өөртөө засах орны Ил гол орчмоор тархаж байна (新疆维吾尔自治区文物局编 2011) (Зураг 2.3-10). Хүн чулууны толгойн засал чимэглэл ба нүүр царайны төлөв байдлаас ажиглавал толгойдоо гурван дэлбээт титэм зүүсэн эмэгтэй хүн болохын магадлал их болно.

VI зууны сүүлчээс VII зууны эх болтол, баруун Түрэгийн хаант улсаас Шы Гуо (石国shí guó) улс (одоогийн Узбекистаны Ташкент хотод) тархаасан зоосны нүүр талд нь ноёрхогчдын хөрөг зургийг сийлж, ар талд нь гурван дэлбээт титэм зүүсэн баруун Түрэгийн Тун Ябгу хаан хааны хөргийг сийлсэн байдаг (Зураг 2.11).

Казахстан улсын археологич З.Самашев 2021 онд Казахстаны зүүн хэсэг дэх Тарвагатайн хойд хэсэг Ченаловскийн бунхны баруун талд, Баруун Түрэгийн хаант улсын үеийн хааны бунхныг илрүүлж, археологийн малтлагын явцад их хэмжээний зэр зэвсэг, адууны тоног хэрэгсэл, алтан зэмсэг, зэс эдлэлийг малтаж илрүүлсэн байна. Үүнээс гадна, онгоны зүүн хэсгийн тахилгын газраас нэг бүлэг хойлгын эд олджээ. Эдгээр эртний олдворын дотор судлаачдын анхаарлыг хамгийн их татсан нь нэг хос, Түрэгийн хааны хөрөг дүрийн сийлбэр дэх бүсний алтан гархи юм. Хос алтан гархины гадар хэлбэр дүрс, хэмжээ ижил бөгөөд бадам цэцгийн хэлбэр дүрстэй байна.

Энэхүү бүсний алтан гархи (бүсний арал) нь тал дугуй зууван хэлбэртэй, дундаа нүхтэй, голдоо Түрэгийн хааны суугаа дүрийг урлан сийлсэн байна.

Ерөнхийлөн үзвэл, Алтайн уул түүнээс баруун тийш Долоон усны голын сав газар амьдарч байсан түрэгүүд гурван дэлбээт титэм зүүх уламжлалаа хадгалсаар байжээ. Эхэндээ Түрэгийн гурван дэлбээт титмийг умай дагина буюу бөө удган зүүж байснаа хожим нь аажмаар хөгжөөд таван дэлбээт титэм болж



Зураг 2. Гурван салаат титэм бүхий олдворууд: 1 Алтайн Кудыргэгийн Түрэгийн тахилын онгоны газрын хүн чулуу, 2. Киргиз улсын Суутту-Булаг М54 булшаас олдсон ясан сийлмэл, 3. Өмнөд Казахстаны нутаг Когалы хэмээх газрын (2-р булш) хүн чулуу, 4. Өмнөд Казахстаны Таласс голын чулуу, 5-6.- Киргиз улсын Дарьпалан (达尔帕兰河 Da'erpalan) голын гурван салаат титэмт хүн чулуу, 7-9. Киргиз улсын Караган дахь гурван салаат титэмт хүн чулуу, 10. БНХАУ-ын Шинжаан Уйгурын өөртөө засах орны Ил голын титэмт хүн чулуу, 11. Узбекистан улсын Ташкент хот орчмоос олдсон баруун Түрэг улсын үеийн хүрэл зоос, 12. Казахстан улсын баруун Түрэгийн тахилын цогцолбороос олдсон алтан бүсний гархи

хувирсан бөгөөд Түрэгийн Ашина овгийн хааны хэргэм зэргийн бэлгэдэл титэм болсон бололтой.

Түрэгийн хожуу хаант улсын хааны титэм хийгээд нүүдэлчин аймаг угсааны шувуу шүтлэг хийгээд зан заншлын тухай

Түрэгийн хожуу хаант улсын хааны титмийн дээрх шувууг магадлан тогтоох асуудлын тухай судлаач бүр өөр өөрийн үзэл, санаа дэвшүүлжээ. Тухайлбал, Линь Мэй Цүн (林梅村 lin mei cun) үзэж буйгаар, домгийн шувуу бол нүүдэлчин үндэстний хамгаас хайртай авын харцага мөн, даруй Хятаны үеийн “шонхор” шувуу гэсэн (林梅村 2005) бол Луо Фөн (罗丰 luo feng)-ний үзэж байгаагаар бол, хааны титэм дээрх шувуу бол улбар шувуу буюу улаан богширго (朱雀-той адилавар шувуу мөн гэжээ (罗丰 2018: 125).

Мөн Чэнь Лин (陈凌 chen ling) Билгэ хааны алтан титмийн төв дундах шувууны дүр бол улаан богширго

гэж үзсэн бөгөөд Жун юань (中原 zhong yuan) орны бурхан шашны Махаранзын дүрслэл болох улаан богширго буюу улбар шувууны (朱雀冠) титэмтэй холбоотой гэж үзжээ (陈凌 2013: 170). Зохиогчийн үзэхээр, иймэрхүү шидэт шувууг улаан богширго гэж магадлах нь зохисгүй шиг, харин гарди шувуу хэмээвэл зохистой болов уу. Улаан богширго нь тогос шиг мөртөө могойн дүрс бүхий шидэт шувуутай адил, дундад улсын эртний домогт ердөө өмнөд орны сахиус байж, хожим нь бумбын шашны шүтлэг болов гэжээ.


Үүний тухай зарим эрдэмтдийн үзэхээр, “Улаан богширго ба гарди бол хоёр өөр төрлийн шидэт шувуу мөн, гарди нь улаан богширго нэн эрт үед байж, хожим нь гарди ба улаан богширго бүгдээр тогосын дүрс хэлбэрийн хувиралт өөрчлөлтийг аван хувирч, хоёулынх нь дүр төлөв аажмаар адилавар болсон байна” (徐华铛 2010: 93-99) гэжээ. Өөрөөр хэлбэл, эдгээр шувууны адил бус хэлбэр төрх нь харилцан

уусаж, хоёул дундын гарди шувууны соёлыг буй болгон бүрэлдүүлжээ.

Уламжлалт ярианд, гарди бол шувуудын төрлийн хаан байж, эртний хятад улсын хааны эрх ямбаны бэлгэдэл болж байжээ. Гарди шувууг “Хуа-и и юй” толь (“夷譯語”)–ийн араатан жигүүртний бүлэгт, “гарди” (凤凰) гэх хятад үгийг “хангарди” хэмээн орчуулжээ. Гарди буюу хангарди нь эрэгчин, галбинга гэдэг нь эмэгчин, ерийн үгэнд хоёулыг хамтад нь гарди хэмээсэн байна. Гарди хэмээгч домогт гардаг шидэт шувуу мөн юм. Эртний бичиг сударт тахиа толгойтой, могой хүзүүтэй, хараацай эрүүтэй, яст мэлхийн нуруутай, загасан сүүлтэй, таван өнгийн өд сөдтэй, зургаан тохой шахам нисдэг жигүүртэнг өгүүлмүй гэжээ (Баянбат 1990: 152). Тан улсын үеэс эхлэн гарди шувуу аажмаар эртний шидэт шувуунаасаа бэлгэт шувуу буюу тэнгэрийн шувуу болон хувирч, эзэн

хаан, жанжин, сайдаас аваад эгэл харц ард хүртэл бүр гарди шувууг бахархдаг болжээ. Иймээс Тан улсын үед гарди шувууны хээ угалзын урлаг цэцэглэн хөгжиж, тал нутгийн нүүдэлчин аймаг угсааны шувуу шүтлэгтэй уусалдан, Түрэгийн язгууртны тахилын онгон цогцолборын хавтан чулууны гол чимэглэл болсон байна.

Сүй, Тан улсын үеийн чулуун агуйн ханын зураг, онгон булшны археологийн малтлагаар илрүүлсэн алт, мөнгөн эдлэл, торгон нэхмэлийн зүйлсийн дээр гарди шувууны дүрийг урлаж сийлсэн байдаг. Жишээ нь, Тан улсын эхний үед байгуулсан Могао (莫高窟) агуйн 71 дүгээр агуйн чимэглэлд гардийн дүр зургийг сийлжээ (зураг 3.1). 1970 онд Сиянь хотын Хө Жя Цунь (何家村he jia sun) тосгоноос Тан улсын үеийн гарди галбингийн дүр зураг сийлсэн мөнгөн таваг хийгээд мөнгөн хайрцгийг илрүүлжээ (齐东方、申秦雁 2003) (Зураг 3.2-3.3).



Зураг 3. Гарди, галбингын дүрслэл VI-VIII зуун:

1. Могао агуй 71-р агуй дахь гардийн дүрс бүхий ханын зураг, 2. Сиань хот Хө Жя Цунь (何家村he jia sun) тосгоноос олдсон Тан улсын үеийн гардийн (галбин) зураг бүхий мөнгөн пял таваг, 2-3. Сиань Хө Жя Цунь (何家村he jia sun) тосгоноос олдсон Тан улсын үеийн гардийн (галбин) зураг бүхий мөнгөн хайрцаг, 4. Тухунь хаан угсааны онгоноос илэрсэн гардийн хээ бүхий зэмсэг хийгээд алтан титэм, 5. Хөшөө Цайдмын нэгэн тахилын онгоны хавтан чулуун дахь гарди, галбингын дүрслэл, 6. Күл чурын тахилын онгон цогцолборын (723-25 он) хавтан чулуун дахь гарди галбингын төрөл, 7. Мэлхий толгойн чулуун яст мэлхийн хажуу дахь гардийн дүрслэл, 8. Пүгү аймгийн захирагчийн бунхант булинаас олдсон модон галбинга

2018-2019 онд Чи Лянь Шан (祁连山qi lian shan) уулын өмнө Цайдамын хотгорын Дулаан шианы Рашаант (热水re shui) -ын Чюань Гөү (泉沟quan gou) -1 гэх Тухунь (吐谷浑) -ны хааны угсааны онгоноос VII зууны жараад оноос VIII зууны дунд үед холбогдох нэгэн алтан титмийг илрүүлжээ.

Алтан титмийн ар өвөр талд нь тэгш хэмт босоо луугийн дүр дүрслэлтэй бөгөөд хоёр хажуу талд нь тус бүр бадамлянхуа цэцгийн дэлбээ дээр ногоон оюу шигтгээн дээр гардийг урлан сийлж, эргэн тойронд нь таван багц мөнх ногоон мөчрөөс навч ургаж буйгаар дүрсэлсэн байна (中国社会科学院考古研究所等 2020: 19-37).

Алтан титэм нь таван хэсэг оюу ногоон цэцгийн дэлбээгээр бүтэж, гардийн хошуу нь бүргэдийн хошуутай, амандаа цэцэг зууж, өд сөдөө дэлгэн дүүлэн нисэх гэж байгаа мэт байна (Зураг3.4). Дээр дурдсан археологийн судалгааны малтлагаас илрүүлсэн гарди шувууны онцлог бол тахиа толгой, бүргэд хошуутай, дээд биеийн хэсэг нь төвлүүн тэгшхэн, сүүлний хэсгийн өд сөд нь дэлгэрч байгаа цэцэг адил байдаг. Энэ мэтчилэн гарди шувууг шүтдэг байсан учраас эртний түрэгүүдийн оршуулгын зан үйлд холбогдох хамгийн нийтлэг зүйл болох тахилын хавтан дээр хүртэл шувууны дүрс сийлсэн нь тохиолдоно.

Тухайлбал, Монгол Улсын Орхон голын хөндийн Хөшөө Цайдам дахь Күлтегиний гэрэлт хөшөөний ойролцоох нэгэн тахилын байгууламжаас жимс зуусан гарди, галбинга хоёр шувууны дүр бүхий тахилын хавтан гарсан байна (Зураг 3.5). Үүнтэй төстэй нэгэн зүйл бол Өвөрхангай аймгийн Хархорин сумын мэлхий толгой хэмээх газар буй яст мэлхий чулууны хоёр гуян дээр гарди галбингийн дүр зургийг сийлжээ (Зураг3.6). Мөн Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хөшөөн тал хэмээх газар байх тахилын хавтан чулуун дээр шувууны дүрс бий (Зураг 3.7). (Аззаяа 2007). Бас Монгол Улсын Төв аймгийн Заамар сумын нутгаас илэрсэн Теле угсааны Пүгү аймгийн захирагчийн бунханаас гардийн дүр зурагтай модон сийлбэр олджээ (Зураг 3.8). Эдгээр археологийн судалгааны олдвор дээр урлаж сийлсэн гарди шувууны онцлог нь толгой өргөн цээж тэнэгэр, жигүүрээ дэлгэн дүүлэн нисэх гэж байгаа мэт байна.

Гардийн хошуу нь бүргэдийн хошуу шиг байж, заримыг нь амандаа үр жимс, цэцэг зууж байхаар урлан сийлж, эргэн тойронд нь бадам цэцэг, навч, цэцгийн хээ угалзаар засан чимэглэжээ. Эдгээр чимэглэл урлал нь нэн илүү ид шидчилсэн шувууны онцлогтойгоор дүрсэлсэн нь хүчирхэг амьтан, тэнгэрийн шувуу болохыг илтгэсэн бололтой.

Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөний дунд шувуун шүтлэгтэй хамаатай дурсгал төв Азийн нутгаар өргөнөөр тархсан байдаг. Тухайлбал Монгол улсын Булган аймгийн Хөл Асгатын хөшөөний хавтан

чулуун дээр гурван эрэгтэй сууж буйгаар дүрсэлсэн ба баруун гар талын хүний толгойн дээд талд нь нэг шувуу сийлсэн байдаг (大泽孝 2010: 1-73) (大泽孝、铃木宏节 2009: 119-127) (Зураг4.1). Төв Азийн Казахстаны Долоон ус голын чулуун хүн ба Киргиз улсын Иссик көл нуурын хүн чулуу (Зураг 4.2-4.3) (Напил 2021) мөн Өвөр Монголын Тайвас хошууны хүн чулуу (Зураг 4.4) цөм зүүн гартаа хундага барьж, баруун гартаа шонхор шувуу суулгажээ. Шидэт шувууны дүр зураглалтай адилтгавал, эдгээр шувууны дүр зураглал нь нэн бодитой байж, тал нутагт үргэлж харагддаг догшин жигүүртэн шонхор болох нь яриангүй юм.

Хөл Асгатын хавтан чулуун дээрх харцгай шувуу хийгээд төв Ази болон Хятад улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Тайвас хошуунд байгаа хүн чулуун дээрх шувууны дүр зураглал нь Билгэ хаан, Күлтегин, Кутлуг хааны тахилын онгоноос илрүүлсэн олдвор дахь гарди шувууны дүрслэлийн эх үүсвэр байж таарна. Түүний урлагийн хэв намбаас үзвэл, Хөл Асгатын хөшөөний чулуун хавтан дээрх шувуун сийлмэлийг говийн ар дахь тухайн газрын дархан бүтээж, Билгэ хаан болон Күлтегиний титэм дээрх шувууны дүр зураг нь Тан улсын хааны ордны дархад урлаж сийлсэн байж таарна. Тан улсын хааны ордны дархад Түрэгийн язгууртны шаардлагаар Жунюань орны янз хэвээр шонхор шувууг титэм дээр сийлэх гэсэн боловч Тан улсын хүмүүсийн бахархан шүтдэг гарди шувууны дүрс хэлбэрээр сийлсэн байжээ.

Түрэг, Монгол угсааны эртний нүүдэлчин үндэстэн дээр үеэс харцгай, шонхор зэрэг догшин жигүүртнийг шүтэн биширдэг заншилтай байсан нь археологийн олдвор, сурвалж бичиг зэрэгт үл мөрөө үлдээжээ. Харцага, шонхор, ууль зэрэг жигүүртнийг овог аймгийн сүлд болгож байсан юм. Археологийн олдворыг үндэслэвэл харцага, бүргэд мэтийн догшин жигүүртнийг дээдлэн үзэх ухамсар эрт үед бүр түгээмэл оршиж байсныг Ордосын Хангин хошууны Ар Цайдмаас малтаж илрүүлсэн Хүннүгийн язгууртны шонхор шувуун оройтой алтан титэм ба Сяньбигийн үеийн шувуун дүрст санжлагат алтан титэм гэрчилж байна.

Мөн Монголын нууц товчооны 63-р хэсэгт Дэй цэцэн цагаан шонхрыг Хиан аймгийн сүлд гэж Есүхэй баатарт хэлж байснаас үзвэл, Монгол үндэстний харцага шувууг шүтэж байсан нь маш эртний үүсэл гаралтай. Монголчууд ер нь эрт дээр үеэс харцага шонхор мэтийн шувууны эрэлхэг шаламгайг бахархан шүтэж байснаас “харцгай шувуу суусан мэт малгайтай” (Улаан 2005: 348) хэмээгдэж байсан сурвалжийн тэмдэглэл байдаг. Энэ бүхнээс үзэхэд, эртний түрэг, монгол хэлтний олон аймаг угсааныхны шонхор шувууны шүтлэг заншил нь нүүдэлчдийн ид хүчийг эрхэмлэн, идтэн баатрыг шүтэн дээдэлдэг уламжлалт соёл сэтгэхүйтэй шууд холбоотой.

Түрэгийн хожуу хаан улсын хааны титмийн соёл

Эртний түрэг хэлэнд “титэм” –ийг “тас”, эртний Арабын Миропрос хэлэнд “(جالت) (taj)”, уйгур хэлэнд (titim), Хуа-и и юй толь (华夷译语)-ийн орчуулгад монгол хэлэнд “titim” (的贪) гэж, (тэргүүн титэм буюу толгойн титэм) гэсэн утгатай гэж тэмдэглэсэн байдаг. Түрэгийн хааны титэмд түрэгүүдийн шашин шүтлэг агуулагдаж байхын хамт адил бус соёлын солилцооны харьцааг тусгаж байдаг. Энэ талаар археологич У.Эрдэнэбат нэгэнтээ тэмдэглэсэн байдаг бөгөөд тэрээр “Дундад улсын соёлын оргил хэмээн зүй ёсоор үнэлэгддэг Тан (618-907) улсын үеийн хятадад суурьшмал, нүүдэлчин ард түмнүүдийн соёлын солилцоо нэн эрчимтэй явагдаж байсны жишээг махчин шувууг сургаж ан хийх урлагаас үзэж болох юм. Тан улсын үед олон нийтэд хувийн амьдралын хэрэгцээний нэгэн адил шувуу чухал үүрэгтэй болжээ. Хятадууд бүргэд, шонхор, харцага, хяргуйг анд сургаж, тагтааг шуудан захидал хүргэхэд ашигладаг байв. ... Тэр үеийн бичгийн сурвалж, археологийн олдворууд, бунхны ханын зураг, шавар хүүхэлдэй, уран зургийн дурсгал тэргүүтнээс үзэхэд Тан улсын эзэн хааны ордны харцага, шонхор, бүргэд, хяргуй зэрэг шувуудыг сургах ажлыг умар зүгийн нүүдэлчдийн зэрэгцээ “баруун зүгийн бүдүүлгүүд” хэмээгдэх Дундад Азийн ард түмний төлөөлөгчид голлон эрхэлж байсан нь мэдэгдэнэ. Тан улсын эрин буюу VI-X зууны үед цэргийн эрхтэн дархтны хувцас, өмсгөлд байгаас харж болно. Том биетэй юм уу аймшиггүй зориг, хурц шаламгай чанарын илэрхийлэл болгож шунгаж буй махчин шувууг дүрслэх уламжлал дорно дахинд

түгэн дэлгэрчээ. Энэ нь тэдний бичгийн түшмэдийн зүсмийн хувцаснаас ялгарах гол тэмдэг болж байсныг тэр үеийн жанжин, сурвалжит ноёд яваандаа үлгэр домгийн галт шувууны дүрстэй гоёмсог титэм хэрэглэх болсныг археологийн олдворууд гэрчлэн харуулна” (Эрдэнэбат 2014: 47) хэмээн маш тодорхой өгүүлжээ

Түрэгийн хожуу хаант улсын хааны титэм дэх бөө мөргөлийн нөлөө

Бөө мөргөлд шувуу бол тэнгэрт нэвтэрдэг шүтээн гэж, хамаг хурдан өндөрт нисэж байгаа шувууг сахиусны элчээр үздэг. Түрэгийн хаан угсааны титмийн соёлын агуулагдахуун эртний бөө мөргөлийн шүтлэгээс эх сурвалжтай.

Бөө мөргөлийн үндсэн үзэл бол юм бүхэн сүнстэй байх явдал болно. Сүнс мөнх орших бөгөөд адил бус хүн ба байгалийн бодисын дээр шилждэг. Ялангуяа хүн нас барсны дараа, сүг сүнс нь байгаль ертөнцийн элдэв зүйлийн сахиус болон чөтгөр шуламстай харилцдаг гэж үздэг. Түрэгүүд хүний сүг сүнсийг шувууны дүрд шингэсэн гэж үзэн, оршуулгын газрын хавтан чулуун дээр шувуу сийлэх буюу чулуун хүний гарт шувуу барьсан дүрийг урлан тэнгэр өөд явахыг бэлгэдэг. Эртний түрэгүүд үхэхийг “нисэх одох” буюу “халин нисэх” гэж хэлдэг байжээ. Орхоны хөндийн руни бичгийн хөшөөн бичээст ердөө “uša” гэдэг үгээр нас нөгчигсдийн сүнс шувуу болон нисэн одогийг илтгэдэг. Жишээлбэл, Күлтегиний гэрэлт хөшөөний зүүн талын 16-р мөрд, Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 13-р мөр “qaṇim: qaṇan törüg: qazṇanir: uša: barmis (Миний эцэг хаан улсыг байгуулж, төрийг



Зураг 4. Шонхор шувуу сийлсэн хүн чулуун хөшөө: 1. Хөл Асгатын хөшөө, 2. Казахстан улсын Долоон усны хүн чулуу, 3. Киргиз улсын Иссык көл (伊塞克湖)-ийн хүн чулуу, 4. БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Тайвас хошууны хүн чулуу

үүсгэв. Өөрөө тийн нисэн одов) (耿世民 2005: 145) гэх мэтчилэн өгүүлсэн байдаг. ЗХУ-ын угсаатан зүйн эрдэмтэн Василий Владимирович Бартольд хэлэхдээ “Түрэгүүдийн үндэстний шүтлэгийг үндэслэвэл, хүний сүнс нь нэг шувуу буюу нэг хорхой болж хувирдаг. Хүн үхдэг нь түүний халин нисэх (ица) -г хэлж байна. Түрэгүүд урт хугацааны турш, цаашилбал исламын шашныг авсны дараа, тэр үхчихлээ гэсэн утгыг бас sungar bolty (Тэр шонхор болжээ) гэсэн үгээр илтгэдэг юм” гэжээ (威廉·巴托尔德著, 罗致平译 1984: 16).

Төв Ази ба Монгол Улсад тархаж байгаа хүн чулууны гартаа барьсан шувуу бол талийгаачийн сүнсийг ачаалагч буюу тээн явагч мөн. Энэ нь хаад ихэс, язгууртанд хүний сүнс шувуу болон нисэн оддог гэдэгт итгэдэг байсныг давхар гэрчилж байна. Эртний нүүдэлчид байгаль дэлхийн сүр хүчийг тэнгэртэй холбон төсөөлж “Мөнх хөх тэнгэр” -ийг хамаг шүтээнийхээ төв болгон сүсэглэн биширч, улмаар жигүүртэн шувууг тэнгэрийн төлөөлөгч хэмээн үздэг.

Гэхдээ гарди хэмээх домгийн шувууны дүрийг өөрийн бодит ахуйд үргэлж тохиолддог харцага, бүргэд, тас, ууль мэтийн догшин жигүүртний төрх байдалд домог зүйн сэтгэлгээ оруулан үлгэрлэн бүтээжээ. “Гардийг гол төлөв махчин шувуунд байдаг хүчирхэг хошуу, хумс, далавч, сүүлний өдийг авч, дээр нь үхрийн эвэр, нүд, хамар мэт олон аймшигт төрхийг илтгэх эрхтнийг нэмж” (Идэмжав 1992: 35) ид шид домгийн сүр хүчийг илтгэсэн байна.

Археологийн судалгаагаар илрүүлсэн Түрэгийн хааны титэмд жигүүрээ дэлгэн нисэх гэж буй гарди шувуу, түрэгийн язгууртны тахилын хавтан чулуун дээрх гарди шувууны дүрийг сийлсэн нь түрэгүүд бөөгийн шашны нөлөөг хүртэж шувууг тэнгэрийн сахиусны элч гэж үздэгийг гэрчлэн харуулж буй хэрэг хэмээн үзэж болох юм. Түрэгийн дараа Монголын өндөрлөгт мандсан монголчууд хангарди хэмээх энэхүү домгийн шувууг маш сүсэглэн, уул хайрхны хад чулуунд мөнхжүүлэн зураад, мөргөж, даатгаж байсан бөгөөд хүч чадал, омог сүрийн бэлгэдэл болгож байдаг байна. Монгол бөхийн их шувуу нисэж буй маягтай дэвэлтийг хангарди дэвэлт гэдэг.

Мөн Монгол бөхийн зодог буюу өвдөгч дэх жигүүртэн дүрс бүхий зургийг хангарди гэдэг. Хөх нуурын Тайж нар хошууны бөөгийн дуудлагад гардаг “бухын эвэр, буурын соёо, хангардийн жигүүр, сайн эрийн бөх” (Сэнгэ 1998: 103) гэдэг шүлэглэл ба жигүүр дэлгэн нисэх шувуун дэвэлт нь эртний Түрэгийн үе дэх хангардийн шүтлэгийн ул мөр болох нь лавтай.

Түрэгийн хожуу хаант улсын хааны угсааны титэм дэх бурхны шашны нөлөө

552 онд Түрэгийн Түмэн хаан Жужаны ноёрхлыг түлхэн унагааж, говийн ард Түрэг хаант улсыг байгуулжээ. Түрэгүүд хэдийгээр бурхан шашны шүтлэгийг хүлээн авсангүй боловч говийн ард бурхан шашны нөлөө үргэлжилсээр байжээ. Жишээлбэл бараг VII зууны үед Түрэгийн хаант улсын дотоодын байдлыг тэмдэглэсэн брахма үсгээр сийлсэн “Хүйс толгойн хөшөө”-ын дээр бичигдсэн нэг аймгийн тэргүүний нэрийг “*Bodhisattva*” гэсэн нь даруй “бодисадва” болно. Энэ хөшөөн бичгийн агуулгаас Түрэгийн хаант улсад бурхны шашны нөлөөг хүртэж байсан гэдгийг харуулж байна. Хятад хэлний түүхэн материалд тэмдэглэснээр, Түрэгийн нэгдүгээр хаант улсын сүүлч үеийн Уйгурын түрүүний нэр нь “бодисадва” гэдэг нэрээс бурхны нөлөө дэх холбоотой гэж үзсэн байна (包文胜 2021: 117). VI зууны дунд үеэс эхэлж, Түрэгийн хаант улс Умард Жөү улс, Умард Чи улстай ургийн харьцаа байгуулжээ. Ялангуяа 568 онд Мухан хааны охин Умард Жөү улсын Ү ди (周武帝zhou wudi) хаантай ураглалцан мордсоны дараа, түрэгийн язгууртнууд олон Чан ан (长安chang an) -д урт хугацаагаар амьдарч эхэлжээ. Түрэгүүд Чан ан-д Жун юань (中原zhong yuan) орны эд эрдэнэсийг эдэлж, хээнцэр тансаг амьдралыг өнгөрөөн, жүневэн орны соёлын нөлөөг гүн хүртэж, өмнө умрын соёлын солилцоог ахиулсан байдаг “Сүй улсын бичиг (《隋书》, 卷八四《突厥传》 1973年 1865; 杨富学、高人雄 2003; 林梅村 1994).

“Түрэгийн намтар”-т тэмдэглэснийг үндэслэвэл, Түрэгийн нэгдүгээр хаант улсын Татбар хааны үед (572-581 он), умард Чи (北齐bei qi) улсын бурхны шавь Хүй Лин (惠琳hui lin) Түрэгийн хааныг ятган бурхны шашныг шүтүүлж, сүм хийдийг байгуулснаас гадна элч томилон умард Чи улсад ирүүлж “*Vimalakirti*” (净名jing ming), Nirvana (涅槃nie pan), “*Avatamsaka*” (华严hua yan) зэрэг ном судрыг залж “Арван уншлагын цааз”-г туурвин бичжээ.

574 онд, умард Жөү (北周bei zhou) улс бурхны шашныг эхлэн хязгаарласнаас болж, Жянь Туо Лөү Гуо (犍陀罗国qian tuo luo guo) улсын хутагт багш Дү На Жюэ Дуо (阇那崛多du na jue duo) Түрэгийн хаант улсаар өнгөрөн улсдаа буцах замд нь түрэг хаант улсын Татбар хаан түүнийг үлдээн авч, арван жил улсдаа бурхны шашныг дэлгэрүүлжээ.

Үүний нэгэн баримтыг дурдвал, 2011 онд Монгол Улсын Булган аймгийн Баяннуур суманд малтан илрүүлсэн бунхны ханын зураг, модон галбинга, урт ишт алтан бадам цэцэг зэрэг бурхны шашны соёл бүхий түүхийн үнэт олдвор нь Түрүү Түрэгийн хаант улс мөхсөний дараа, Тан улсын говийн ар дахь илбэн тохинуулах ноёрхлын үеийн бурхны шашны

уламжлан дэлгэрсэн байдлыг зохих хэмжээгээр тусгасан байна (Очир 2013; 阿·敖其尔等, 萨仁毕力格译 2014; Очир 2017).

Хожуу түрэг хаант улсын үүсгэн байгуулагч Кутлуг хаан болон Күлтегиний чулуун хөрөг дахь титмийн хэв маяг, хийц төлөвөөс Тан улсын соёл иргэншилд нөлөөлөгдсөн гэдгийг олж харах болно. Хааны титмийн хийц маягийг ажиглавал, Тухайн үед Тан улсын эрэгтэйчүүдийн малгай засалд эгц босоо маягийн титэм дуурайсан малгай олон харагддаг байсан юм. Тан улсаас Түрэг улсад томилсон дархад чулуун хөрөг сийлж бүтээх явцад урьдын заншлаар хүн чулууны (малгай) титмийг сийлэхдээ Жун юань (中原zhong yuan) орны эгц босоо маягийн малгай титмийн хэлбэртэй сийлснийг мэдэж болно. Гар урлалын мэргэжлийн талаас авч хэлбэл, Билгэ хааны алтан титэм бол алтыг давтаж, эрдэнийн чулуу шигтгэсэн тал нутгийн уламжлалт гар урлалын мэргэжлийн бүтээл болох юм. Чулуун хөрөг дахь титэм ба алтан титэм нь урлаж бүтээх ур мэргэжил ба эд материалын талд адил бус боловч таван дэлбээт титмийн төв дунд нь гарди шувууны дүрийг чимж хийсэн нь нэг цаг үеийн онцлогийг харуулж байгаа нь илэрхий юм.

“Цө Фү Юань Гүй” (册府元龟ce fu yuan gui) -д тэмдэглэснийг үндэслэвэл, Күлтегинийг нас барсны дараа, ах Билгэ хаан Тан улсаас уран дархад залж, Күлтегиний хөргийг сийлүүлжээ. Үүнд Тан улсын Шюнь Зан (唐玄宗 tang xuan zong) хаан зургаан уран дархан томилж очуулсан гэнэ. “Тан улсын уран дархад Күлтегиний хөрөг дүрийг урлаж дүрсэлсэн нь уран нарийн, Түрэг улсад өөр үгүй гэмээр байжээ. Билгэ хаан урлаж бүтээсэн хөргийг үзээд дүүгээ дахин олж харсан мэт болж, өөрийн эрхгүй сэтгэл эмзэглэв (册府元龟, 旧唐书·突厥传上5117; 新唐书 6053-6054).

Урлаж бүтээх ажил дууссаны дараа, Билгэ хаан уран дархадыг Жун юань (中原zhong yuan) оронд нь хүргэхийн хамт, 50 агт морь бэлэглэж талархлын сэтгэлээ илтгэжээ.

Билгэ хаанаас дүү Күлтегинд зориулан босгосон гэрэлт хөшөөний өмнөх 11~12 мөрт тэмдэглэхдээ: “*Tabγač: qayanta: bedizči: kelürtüm: bediztim: meniγ: sabimün: simdi: Tabγač: qayanīγ: İčreki: bedizčig: iiti: aγar adinčiy: bariq: yaraturtüm: ičin: tišin: adinčiy: bediz: urturtüm: taš toqütdim: köñilteki: sabimün: ol tašqa urturtüm* (Би Билгэ хаан Табгач (Тан улс) -ийн хаанаас уран дархад залж, нэгэн аугаа их онгон байгуулан, дотно гаднаас нь уран сайхан зураг зуруулж, чулуун хөшөө босгон, өөрийн сэтгэлийн үгээ сийлүүлэв)” (耿世民 2005: 120; 芮传明 1998: 219) гэж бичжээ.

Түрэгийн язгууртны тахилын онгоны руни бичгийн сурвалж “Сүй улсын бичиг, Түрэгийн намтар” -т тэмдэглэсэн “модоор онгоны газар болгон гэр өргөө барьж, талийгаачийн дүр төрх, түүний нэг насандаа

байлдан тэмцэж явсан үйл явдлыг зураглан сийлэв” (隋书 1973: 1864) гэсэн хоёр агуулгын талд нэгдэлтэй юм. Үүнээс Тан улсын хааны ордны дархад Билгэ хааны болон Күлтегиний тахилын онгон цогцолборыг байгуулах ажилд оролцож байсныг мэдэж болно.

Билгэ хаан “Хот бэхлэлт барьж, сүм хийд байгуулах” бодолтой байсан ч зөвлөгч түшмэл Тоньюкук “Сүм хийд бол хүнийг ухаан бодлыг ноомой дорой болгож, цэрэг зэвсгээр хүчирхэгжихэд харш болмуй” гэж ятгасан байдаг (旧唐书 1975: 5174).

Эцэстээ Билгэ хаан сүм хийд байгуулах гэсэн бодлоо таягджээ. Билгэ хааны сүм хийд байгуулахыг санаачилж байснаас үзэхэд, Түрэгийн хожуу хаант улсын дотоодод мөн бурхны шашны шүтлэгтэй байсан буюу Тан улсаас Түрэгийн хаант улсад шашин дэлгэрүүлж байсныг харуулж байна. Тийм биш бол Билгэ хаан ямар ч бодит ахуйн нөхцөлгүйгээр гэнэт сүм хийд байгуулахыг санаачлах бололцоогүй юм (包文胜 2021: 117).

Түрэгийн хожуу хаант улс мандахаас өмнө, бурхны шашны соёл нэгэнт Түрэгийн хаант улсын дотоодод гүнзгийрэн орж, Түрэгийн хаант улсын үеийн гарди шувууны хэлбэрт хааны титмийг урлаж бүтээхэд соёлын суурийг тавьж өгсөн байна. Тал нутагт бурхны шашин үргэлжлэн оршиж байсан ба тухайн үед Жун юань (中原zhong yuan) оронд махранзын сүсэг бишрэл ба шувуун хэлбэрт хааны титэм өргөнөөр дэлгэрч байжээ. Иймээс Түрэгийн хааны титмийг урлан бүтээх явцад бурхан шашны урлагийн нөлөөг хүртсэнээр барахгүй, мөн Жун юань (中原zhong yuan) орны бярман (毗沙门pi sha men) шувуун хэлбэрт титмийн хэв заавраар лавлалт болгосон байж таарах юм.

Ерөнхийлөн үзвэл, гарди гэдэг домгийн шувууны шүтлэг нь түрэгүүдийн дунд эхнээсээ байсан биш. Харин түүнтэй төстэй болох шонхор шувуу бол түрэгийг багтаасан нүүдэлчдийн эрхэмлэн шүтдэг жигүүртэн болно.

Бурханы шашны нөлөө хийгээд Тан улсын соёлын нөлөөг гөрдөж, нүүдэлчдийн шонхор шувууны шүтлэгтэй аажмаар уусалцан, нүүдэлчдийн соёл урлаг бүхий гарди шувууны дүрийг бүтээсэн юм.

Дүгнэлт

Түрэгийн хаант улсын хааны титэм нь эртний түрэгийн хувцас заслын соёл, шашин шүтлэгт агуулагдаж байсан балар эртний бөө мөргөлийн соёлын уламжлал ба дэлгэрүүлэлт зэргийг нэн гүн давхаргын утга ахуйг гүйцэд илрүүлсэн байна. Гурван дэлбээт титэм хамаг анхандаа түрэгийн үүслийн орон Алтай нутаг орноос үүсэж, түүхэн урт хугацааны явцад Түрэгийн хожуу хаант улсын үед таван дэлбээт титэм болж хувирчээ. Үүний дотор, Түрэгийн хаант улсад шувууны чимэгтэй хааны титэм буй болсон нь Тан улсын үеэс Түрэгийн хожуу хаант улсад уламжлагдсан бурхны шашны соёлтой шууд холбоотой юм.

Түрэгийн хожуу хаант улсын хааны титмийг урлаж бүтээсэн Тан улсын уран дархад Жун юань (中原 zhong yuan) орны соёлоор загвар болгон дуурайхын хамт, тал нутгийн үндэстний соёлын уламжлалыг ч уусгажээ.

Түрэгийн хаант улсын шувууны чимэглэл дэх титэм нь бөөгийн шүтлэг ба бурхан шашны урлагийг уусгаж, соёлын олон эшт онцлогийг харуулжээ.

Түрэгийн хааны титмийн ирэлт үүсэл, хэлбэр маяг, хэв загвар соёлыг шинжлэн судлах нь VI-VIII зууны үеийн Түрэгийн хаант улс болон Тан улсын соёлын солилцоо харилцааг судлахад тун их ач холбогдолтой юм.

Abstract

The Imperial Crown of the Second Turkic Khaganate: Tradition and Cultural Significance

Changhai (Ürgendalai)

The imperial crown of the Second Turkic Khaganate symbolized the political authority, divine sanction, and noble status of the Ashina royal lineage. Archaeological discoveries from royal funerary complexes of the period include the golden crown attributed to Bilge Khagan, as well as the sculpted head portraits of Kul Tegin and Qutlugh Khagan. These rare and invaluable imperial regalia provide not only crucial material for examining the religious beliefs, ceremonial customs, and attire traditions of the Turkic state, but also offer significant evidence for understanding cultural interactions between the Turkic Khaganate and the Tang dynasty.

Drawing on historical textual sources, archaeological findings, and ethnological data, this paper reconstructs the typology, stylistic evolution, and symbolic system of the Turkic imperial crown during the Second Khaganate. Furthermore, it explores the cultural meaning embedded in these royal emblems, with special attention to motifs of bird worship and ritual tradition.

Keywords: Second Turkic Khaganate; imperial crown; Ashina; bird symbolism; cultural exchange; archaeology

Ном зүй

Азаяа, Б. (2007). “Монгол, Түрэг угсаатны “шувуу” шүтлэг.” *International Scientific Journal* №1.

Баянбат, Г. (1990). Монголчуудын модон шүтлэг. Хөх хот: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.

Баяр, Д., Амартүвшин, Ч., Энхтөр, А., Гэрэлбадрах, Ж. (2021). Билгэ хааны үнэт эрдэнэс. УБ.

Баяр, Д. (2004). Археологические изучение поминального памятника в честь Билге кагана. Алматы.

Идэмжав, Ч. (1992). Монгол ардын хээ угалзын эх дүрснүүд. Хөххот: Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Кубарев, В.Д. (1984). Древнетюркские изваяния Алтая. Новосибирск.

Напил, Б. (2021). “Их талын нүүдэлчдийн тахилын онгон цогцолборууд болон хүн чулуун дурсгалууд: Түрэгийн үеийн угсаатан-соёлын онцлог (Археологийн судалгааны эх сурвалжууд. 1-р хэсэг).” *International Scientific Journal* №2.

Очир, А., Эрдэнэболд, Л. (2017). Эртний нүүдэлчдийн урлагийн дурсгал. УБ.

Очир, А., Эрдэнэболд, Л., Харжаубай, С., Жантегин, Х. (2013). Эртний нүүдэлчдийн бунхант булшны малтлага. УБ.

Руденко, С.Л., Глукхов, А.Н., (1927). Могильник Кудыргэ на Алтае, материалы по этнографии. I.

Сэнгэ, Д. (1998). шувуун шүтлэг, монгол соёл дах өөр дүр хийгээд түүний уламжлал. Хөххот: Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан.

Сэр-Оджав, Н. (1959). “Хүл Тегиний булшнаас олсон хүн чулууны толгой.” *Studia Archaeologica. Tomus. I, Fasc. 6*: 8.

Улаан (2005). Эрдэнийн товчын судлал. Улаанбагана орчуулав, Ляонин: Ляонин үндэсний хэвлэлийн хороо.

Худяков, Ю.С., Табалдиев, К.Ш., Солтобаев, О.А. (1997). “Новые находки предметов изобразительного искусства древних тюрок на Тянь-Шане.” *Российская археология*, 3: 145, 147.

Энхтөр, А., Дархан, К., Напил, Б., Нурболат, Б., Буянхишиг, Ц., Батболд, Г., Далантай, С. (2022). “Кутлук хааны тахилын онгон цогцолбор гэрэлт хөшөө.” *Археологийн судлал 2022, Tomus XLI* 69-87.

Эрдэнэбат, У. (2014). Монгол шувуулахуй. УБ..

[北宋]王钦若等. (1960) 《册府元龟》卷1962、卷999. 中华书局.

[宋]欧阳修、宋祁等撰. (1975) . 《新唐书》. 卷215下《突厥传下》. 中华书局.

[后晋]刘昫. (1975) . 《旧唐书》. 卷194《突厥传

上》. 中华书局.

[唐]魏征等. (1973). 《隋书》卷84, 《突厥列传》. 中华书局.

中国社会科学院考古研究所等 (2020). 《青海乌兰县泉沟一号墓发掘简报》. 《考古》.

包文胜. (2021). 《中国古代北方民族史(突厥卷)》. 科学出版社.

吉谢列夫C.B. 著, 王博译 (2014). 《南西伯利亚古代史》. 新疆人民出版社.

大泽孝. (2010). “ホルアスガト碑铭再考”. 内陆アジア言语の研究, 1-73.

大泽孝、铃木宏节. (2009). “モンゴル国现存遗迹 突厥碑文调查报告”. ウランハートル.

威廉·巴托尔德著, 罗致平译. (1984). 《中亚突厥史十二讲》. 中国社会科学出版社.

徐华铛. (2010). 《中国凤凰造型》. 中国林业出版社.

新疆维吾尔自治区文物局编. (2011). 《新疆草原石人和鹿石》. 科学出版社.

杨富学、高人雄. (2003). 《突厥佛教盛衰考》. 《南都学刊》.

林梅村. (1994). 《布古特所出粟特文突厥可汗纪功碑考》. 《民族研究》.

林梅村. (2005). 《毗伽可汗宝藏与中世纪草原艺术》. 《上海文博论丛》.

石渡美江. (2019). “鸟头冠と鸟翼冠”. ヘレニズム—イスラーム考古学研究, 120-140.

罗丰. (2018). 蒙古国纪行. 三联书店.

耿世民. (2005). 《古代突厥文碑铭研究》. 中央民族大学出版社.

芮传明. (1998). 《古突厥碑铭研究》. 上海古籍出版社.

阿·敖其尔等, 萨仁毕力格译. (2014). 《蒙古国布尔干省巴彦诺尔突厥壁画墓的发掘》. 《草原文物》.

陈凌. (2013). 《突厥汗国与欧亚文化交流的考古学研究》. 上海古籍出版社.

陈凌. (2008). 《突厥王冠考——兼论突厥袄教崇拜的有关问题》. 《欧亚学刊(第八辑)》.

霍巍. (2009). 《突厥王冠与吐蕃王冠》. 《考古与文物》.

韦之昊. (2023). 《蒙古草原古代头冠上的神鸟——北方民族鸟形头饰的初步研究》. 吉林大学硕士论文.

齐东方、申秦雁. (2003). 《花舞大唐春何家村遗宝精粹》. 文物出版社出版.

Received: Nov. 4, 2025; Revised: Dec. 15, 2025; Accepted: Dec. 23, 2025

